




# УВС АЙМГИЙН ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛ



Агуулга

I.	Оршил	2
II.	Уур амьсгал	3
III.	Ус, Ургамал	3
IV.	Амьтны аймаг	4
V.	Засаг захиргаа	4
VI.	Эдийн засаг	5
VII.	Орон сууцны нөхцөл	6
VIII.	Аймгийн аюулгүй байдал	7


Бэлтгэсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Д.Гантөмөр

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга П.Тунгалаг

## I. Оршил

Увс аймаг нь Монгол улсын баруун хязгаарт Их нууруудын хотгорт оршдог, 69.6 мянган ам дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, аймгийн нийт хилийн урт 1267 км. Баруун талаараа Баян-Өлгий аймаг, өмнө талаараа Ховд аймаг, зүүн талаараа Завхан аймаг, хойд талаараа ОХУ-ын Тува улстай 575км газар нутгаар хиллэн оршдог. ОХУ-ын Тува улсын Кызыл хотоос 436км зайтай, БНХАкаси улсын Абакан хотоос -690км, БНАлтай улсын Горно-Алтайск хотоос 800км, Алтайн хязгаарын Барнаул хотоос 1040км, Новосибирск хотоос 1230км зайтай оршдог. Уур амьсгал: Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 758.9 метрт буй Увс нуурын ай савын дархан цаазат газар бөгөөд хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 4250 метрт өргөгдсөн Цагаан дэглий оргил юм. Далайн түвшнээс 2400-4126 м өндөр мөнх цаст сүрлэг уулс, 9200 ам дөрвөлжин км талбай бүхий элсэн манхан, Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг томоохон нуурууд, Тэс, Ховд, Хархираа, Түргэн, Хангилцаг, Туруун Завхан зэрэг том голууд нь Увс аймгийн байгалийн үзэсгэлэнг цогцлоон бүрдүүлнэ. Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Зун 7 сард +40-50 хэм халж, өвөл 01 сард -40, -50 хэм хүртэл хүйтэрдэг. Увс аймаг нь өндөр уул, ой тайга, өргөн тал, говь олон нуур, гол горхи зэрэг байгаль газарзүйн олон янзын онцлогт тохирсон төрөл бүрийн ургамал, ан амьтан элбэгтэй. 64 зүйлийн хөхтөн, 270 зүйлийн шувуу, 7 зүйлийн загас, 411 зүйлийн ургамалтай. Засаг захиргаа, хүн ам: Дөрвөд далай хаан, Зоригт хааны аймгийг нэгтгэж, 1925 онд Чандмань уулын аймгийг байгуулж, улмаар 1931 оны 2 сарын 6-нд Увс аймгийн хилийн заагийг тогтоосноор Увс аймгийн засаг захиргааны хуваарь үүссэн. Аймгийн төв нь Улаангом, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 93 багтай, 2018 оны жил эцсийн байдлаар 22.0 мянган өрх, 83.6 мянган суурин хүн амтай. Аймгийн төв Улаангом хот нь 31.6 мянган оршин суугчтай, нийслэл Улаанбаатар хотоос 1336 км алсад оршдог.

Зураг 1.



## II. Уур амьсгал

Увс аймгийн цаг уурийн байдал нь Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм. Иймд Увс

нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг бөгөөд өвлийн улиралд агаарын температур 2018 онд хамгийн хүйтэндээ Тэс сум -50.1 хүрсэн ба аймгийн хэмжээнд 1 - р сард агаарын температур дунджаар Тэс сум хасах 38.6 хэм, Зүүнговь сум хасах 37.4 хэм, Улаангом хасах 34.6 хэм хүйтэрч бусад сумдад хасах 33.8 градус хүртэл хүйтэрсэн байна. Хөрсний гадаргын дундаж температур Зүүнговь, Тэс, Баруунтуруун, Сагил хасах 34.0 –хэмээс илүү хүйтэрч бусад сумуудад хасах 31.1 градус хүртэл хүйтэрсэн байна. Зуны улиралд хамгийн дулаандаа 7 - р сард агаарын температур Зүүнговь, Малчин сумдад 33.0 градус хүрч халж бусад сумдад 24.5-32.8 градус хүртэл дулаарсан бөгөөд 2018 онд -2.1с-ийн хэмтэй байсан байна.

### **III. Ус, Ургамал**

Аймгийн нутагт говь-хээрийн бүс зонхилсон өвс ургамал нөмрөгийн хувьд тачирдуухан боловч төрөл зүйл олон, жимс жимсгэний ургамалтай. Хар мод, хус, хуш, нарс, улиас, бургас, улаан харгана, алтан харгана нутгийн ихэнхи хэсгээр тархсан. Зүүнговь, Сагил, Түргэн сумын нутгаар мөнх ногоон гацуур модтой. Увс нуурын эрэг орчим, Тэсийн голын адаг орчмоор улиасан төгөл, бургасан шугуй, тэмээн харгана бүхий алаг өвст, үент, нугын бүлгэмдэл зонхилно. Алтан гагнуур, вансэмбэрүү, алтан хундага, нохойн хошуу, тарваган шийр, халгай, таван салаа, хунчир зэрэг эмийн ургамалтай. Чацаргана, үхрийн нүд, гүзээлзгэнэ, тошлой, мойл, анис, зэдгэнэ зэрэг жимс жимсгэнэ ургадаг.

Увс аймагт 2018 оны байдлаар ойн нөөц бүхий 20961.6 мян.м3 талбай байна. Ойтой талбай 236.6 мянган га, ой дотрхи ойгүй талбай нь 4.4 мянган га-г эзлэж байна.

Аймгийн хэмжээнд гадаргын усны нөөц 3443.9 м3, газар доорхи усны нөөц 168.0 сая м3 байна. Усны 779 эх үүсвэрийг хамгаалтанд авсан байна.

### **IV. Амьтны аймаг**

Тус аймаг 64 зүйлийн хөхтөн, 270 зүйлийн шувуу, 7 зүйлийн загас, 411 зүйлийн ургамалтай. Хан Хөхий, Хархираа, Түргэний уулсаар буга, гахай, аргаль, янгир, ирвэс, шилүүс, хадны суусар, нохой зээх, хээр тал зарим голын хөндий уулархаг нутгаар чоно, үнэг, дорго, тарвага зэрэг зэрлэг ан амьтан амьдардаг. Нууруудад хун, нугас, хотон зэрэг усны шувууд, уул талаар хойлог, тоодог, тас, бүргэд, ёл, Ховд, Бөхмөрөний голд алтан гургалдай зэрэг төрөл бүрийн жигүүртэн шувуудтай. Тэс, Нарийн голын сав нь хүйтэн цуст амьтад амьдардаггүй бүсэд хамаарна. Бөөрөг дэлийн элсний районд хээрийн бүлгэмдэл тархсан. Хонин гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой зэрэг мөлхөгчидтэй. Ан агнуурын амьтдаас хярс, мануул, өмхий хүрэн, солонго элбэг бол агнуурын шувуудаас ногтруу, дагуурын ятуу элбэг тархсан.

## V. Засаг захиргаа

Аймгийн төв нь Улаангом хот, засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум, 92 багт хуваагддаг. Аймгийн төвөөс хамгийн ойрхон сум Түргэн 28 км, хамгийн алслагдсан нь Зүүнхангай сум 365 км зайтай. Хамгийн их хүн амтай, өрхтэй нь аймгийн төв Улаангом сум бөгөөд нийт 31613 хүн ам, 8574 өрх айлтай ба Тэс сум мөн хамгийн их толгой мал буюу 265896 тоо толгой мал тоолуулсан бол хамгийн бага өрх, хүн амтай нь Давст сум ба 435 өрх айл, 1687 иргэнтэйгээр 2018 оны жилийн эцэст тоологдсон байна.

Зураг 2. 2018 оны жилийн эцсийн байдалаар

№	сум	нийт өрх	хүн ам	малын тоо
1	Баруунтуруун	774	2742	73395
2	Бөхмөрөн	580	2292	141223
3	Давст	435	1687	89915
4	Завхан	500	1875	124820
5	Зүүнговь	716	2805	132295
6	Зүүнхангай	651	2353	160708
7	Малчин	670	2522	166560
8	Наранбулаг	1056	4304	248373
9	Өлгий	619	2428	129895
10	Өмнөговь	1155	4681	233152
11	Өндөрхангай	901	3247	201874
12	Сагил	640	2509	178769
13	Тариалан	967	4040	159269
14	Түргэн	605	2110	143959
15	Тэс	1301	5238	265896
16	Ховд	668	2485	161617
17	Хяргас	639	2591	194326
18	Цагаанхайрхан	596	2095	169080
19	Улаангом	8574	31613	200149
20	Бүгд	22047	83617	3175275

## VI. Эдийн засаг

Аж үйлдвэрийн салбарт 19.1 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 21.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, ажиллагсдын тоо 782 болсон байна. Нийт үйлдвэрлэлийн 39.9 хувийг дулаан түгээлт усан хангамж, 53.4 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 6.7




хувийг уул уурхайн олборлолт /зураг-2/ эзлэж байгаа бол энэ нь өнгөрсөн оны жилийн эцэсээс үйлдвэрлэл 40.0 хувиар, бүтээгдэхүүний борлуулалт 51.1 хувиар өссөн байна.

Зураг 3.



Зураг 4.




## VII. Орон сууцны нөхцөл

2018 оны байдлаар Увс аймгийн нийт өрхийн 8754 буюу 38.9 хувь нь аймгийн төвд харин үлдсэн 61.1 хувь нь бусад 18 суманд оршин сууж байгаа ба нийт өрхийн 57.9 хувь нь аймаг сумын төвд, 42.1 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн тоог сууцны төрлөөр нь ангилбал бие даасан тохилог сууцанд 0.3 хувь, гэрт 83.0 хувь, нийтийн байранд 0.3 хувь, орон сууцны байшинд 5.1 хувь, сууцны тусдаа байшинд 11.2 хувь, бусад сууцанд 0.1 хувь оршин сууж амьдарч байна.

Зураг 5.

Байршил	Бүгд	Үүнээс					
		Гэр	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	Бусад сууц
Баруунтуруун	774	551		1	194	27	1
Бөхмөрөн	581	493			88		
Давст	433	399			29	4	1
Завхан	499	470			29		
Зүүнговь	711	625			84	2	
Зүүнхангай	653	485			168		
Малчин	662	581			81		
Наранбулаг	1043	1,022			18		3
Өлгий	622	593	1	1	24		3
Өмнөговь	1145	1,060			84		1
Өндөрхангай	897	748			148		1
Сагил	626	564			56	5	1
Тариалан	959	861			96	2	
Түргэн	598	566			32		
Тэс	1289	1,261			28		
Улаангом	8655	6,100	1,169	62	1,208	109	7
Ховд	663	616			42		5
Хяргас	638	491	1		144		2
Цагаанхайрхан	599	477			122		
Бүгд	22,047	17,963	1,171	64	2,675	149	25

Зураг 6. Нийт өрхийн тоог сууцны төрөл бүтцээр нь




### VIII. Аймгийн аюулгүй байдал

2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 332 болж өнгөрсөн оны мөн үеэс 24 гэмт хэрэг буюу 6.7 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 21 гэмт хэргээр буюу 5.9 хувиар тус тус буурсан байна. Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 181


тохиолдол байгаа нь нийт гэмт хэргийн 54.5 хувийг эзлэж байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл 30 нь эмэгтэйчүүд , 10 нь хүүхэд оролцжээ.

Зураг 7. Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эцэст, тоо



Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 23, согтуугаар үйлдэгдсэн 87, бүлэглэн 24, гудамж талбайд 47, гэр орон сууцанд 115 гэмт хэрэг гарсан байна.


Зураг 8. Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо



Гэмт хэргийн улмаас 1018.5 сая төгрөгийн хохирол учирч, иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 369.2 сая төгрөг буюу 36.2 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед хөрөнгө битүүмжлээгүй байна.

Зураг 9 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг





Ашигласан материал

1212.mn статистикийн лавлах сайт

Uvs.nso.mn

Аймгийн нийгэм эдийн засгийн 2018 оны жилийн эцсийн танилцуулга